ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**2025 XI**

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ




www.1212.mn

# АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он | 3 |
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр | 3 |
| I | Эрүүл мэнд | 5 |
| II | Нийгмийн даатгал | 8 |
| III | Нийгмийн халамж | 11 |
| IV | Гэмт хэрэг | 12 |
| V | Дүүргийн төсөв | 15 |
| VI | Хэрэглээний үнэ | 18 |
| VII | Цаг уур, агаарын бохирдол, аюулт үзэгдэл | 22 |
| VIII | Захиргааны мэдээ | 24 |

## ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | | Хэмжих нэгж | 2021 I-XI | 2022 I-XI | 2023 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI |
|---|---|---|---|---|---|---|---|
| Шинээр төрсөн хүүхэд | | Хүн | 4 473 ↑1.3 | 4 411 ↓1.4 | 4 661 ↑5.7 | 4 363 ↓6.4 | 4 175 ↓4.3 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | | Хүн | 25 082 ↑20.7 ** | 25 183 ↑0.4 | 1 959 ↓92.2 | 1 711 ↓12.7 | 4 316 ↑2.5** |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | | Тоо | 1 795 ↑20.1 | 2 730 ↑52.1 | 3 667 ↑34.3 | 4 391 ↑19.7 | 5 164 ↑17.6 |
| Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт) | | Хувь | 1.5 ↑0.8 | 0.9 ↓0.6 | 0.8 ↓0.1 | 1.7 ↑0.9 | 0.4 1.3 |
| Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж) | Доллар (АНУ) | Төгрөг | 2 849 ↓0.0 | 3 406 ↑19.6 | 3 441 ↑1.0 | 3 413 ↓0.8 | 3 572 ↑4.7 |
| | Юань (БНХАУ) | Төгрөг | 446 ↑3.4 | 475 ↑6.5 | 476 ↑0.2 | 474 ↓0.4 | 502 ↑5.9 |
| | Рубль (ОХУ) | Төгрөг | 39 ↑5.1 | 56 ↑43.6 | 38 ↓32.1 | 34 ↓10.5 | 44 ↑29.4 |
| Дүүргийн төсвийн орлого | | Тэрбум төгрөг | 157.1 ↑54.8 | 298.8 ↑90.2 | 452.8 ↑51.5 | 808.6 ↑78.6 | 463.4 ↓42.7 |
| Дүүргийн төсвийн зарлага | | Тэрбум Төгрөг | 161.6 ↑85.3 | 169.9 ↑5.2 | 410.1 ↑2.4** | 858.9 ↑2.0** | 402.8 ↓53.1 |
| Агаарын дундаж температур | | $^{0}C$ | -8.0 | -10.6 | -11.5 | -5.4 | -8.8 |

## ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

| Үзүүлэлт | Хэм-жих нэгж | 2024 I-XI | | | | | 2025 I-XI | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | |
| Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/ | Тоо | 349 | Баянгол | 8 579 | Налайх | 59 | 357 | Баянгол | 8 797 | Налайх | 59 |
| | | | Чингэлтэй | 1 526 | Багануур | 47 | | Чингэлтэй | 1 490 | Багануур | 47 |
| | | | Сүхбаатар | 679 | Багахангай | 32 | | Сүхбаатар | 688 | Багахангай | 32 |
| Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/ | 0\00* | 12 | Багахангай | 33 | Баянзүрх | 8 | 15 | Багахангай | 18 | Чингэлтэй | 11 |
| | | | Багануур | 23 | Сүхбаатар | 5 | | Багануур | 16 | Баянгол | 10 |
| | | | Баянгол | 11 | Налайх | 5 | | Налайх | 15 | Хан-Уул | 7 |
| 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд | 0\000 | 101 | Баянзүрх | 99 | Налайх | 64 | 194 | Баянзүрх | 213 | Сонгино-хайрхан | 129 |
| | | | Сүхбаатар | 79 | Хан-Уул | 63 | | Багануур | 186 | налайх | 65 |
| | | | Чингэлтэй | 71 | Багахангай | 18 | | Хан-Уул | 155 | Багахангай | 56 |
| Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100 | тоо | 66 | Баянзүрх | 108 | Багахангай | 89 | 71 | Баянзүрх | 116 | Багахангай | 80 |
| | | | Баянгол | 104 | Налайх | 78 | | Хан-Уул | 115 | Налайх | 79 |
| | | | Сонгино-хайрхан | 101 | Багануур | 29 | | Чингэлтэй | 104 | Багануур | 23 |
| 16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг | тоо | 245 | Сүхбаатар | 417 | Сонгино-хайрхан | 142 | 261 | Сүхбаатар | 440 | Багануур | 168 |
| | | | Чингэлтэй | 298 | Багануур | 105 | | Чингэлтэй | 369 | Налайх | 103 |
| | | | Баянгол | 268 | Багахангай | 58 | | Хан-Уул | 277 | Багахангай | 80 |

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.
Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

| | |
|---|---|
| - | гүйцэтгэл байхгүй |
| * | урьдчилсан гүйцэтгэл |
| ** | дахин |

**III.** Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.
**IV.** Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.
/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/




**V.** Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.
/ Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

**IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ**

| | |
|---|---|
| мянга | =1000 |
| сая | $=10^6$ |
| тэрум | $=10^9$ |
| их наяд | $=10^{12}$ |
| мян | мянга |
| % | хувь |
| мм | миллиметр |
| см | сантиметр |
| дм | дециметр |
| м | метр |
| км | километр |
| $м^2$ | метр квадрат |
| $дм^2$ | дециметр квадрат |
| $км^2$ | километр квадрат |
| $м^3$ | метр куб |
| га | гектар |
| мл | миллилитр |
| л | литр |
| г | грамм |
| кг | килограмм |
| цн | центнер |
| т | тонн |
| Вт | ватт |
| кВт.ц | киловатт цаг |
| кал | калори |
| ккал | килокалори |
| Гкал | гигакалори(=$10^9$ калори) |
| с | секунд |
| мин | минут |
| $мкг/м^3$ | микрограмм метр куб |
| м/с | метр секунд |
| ш | ширхэг |
| х.д.х | хэвлэлийн даралтат |

МЭДЭЭЛЭЛ

МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

# ЭРҮҮЛ МЭНД

## 2025 оны эхний 11 сард 4149 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 163(3.8%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 11 сард 4149 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 163 (3.8%) төрөлтөөр буурсан байна. 2025 оны эхний 11 сард эхийн эндэгдэл 2 гарсан бол нялхсын эндэгдэл 12 хүүхдээр буурч, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 хүүхдээр нэмэгдсэн байна.

**ХҮСНЭГТ 3.** **ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**

| Үзүүлэлт | 2023 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI | Өөрчлөлт % |
|---|---|---|---|---|
| Амаржсан эхийн тоо | **4 628** | **4 312** | **4 149** | **-3.8** |
| Амьд төрсөн хүүхэд | 4 661 | 4 363 | 4 175 | -4.3 |
| Эхийн эндэгдэл | 1 | 0 | 2 | - |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 36 | 46 | 34 | -26.1 |
| 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 3 | 6 | 8 | 33.3 |

**ЗУРАГ 1.** **АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД**




Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаар 4316 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2605 (2.5 дахин) хүнээр , 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 93.5 продицмилээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 13.8 хувийг салхин цэцэг, 3.9 хувийг гар хөл, амны өвчин, 3.2 хувийг цусан суулга, 2.8 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 1.9 хувийг тэмбүү, 1.3 хувийг заг хүйтэн, 50.6 хувийг улаан бурхан, 22.5 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

## ХҮСНЭГТ 4. ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 11 сарын эцэст

| Төрөл | Хэмжих нэгж | 2023 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тоо/нэгж | хувь |
| **Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд** | **тоо** | **1 959** | **1 711** | **4 316** | **2 605** | **2.5******** |
| | **10000 хүнд** | **86.5** | **68.9** | **162.4** | **93.5** | |
| Үүнээс: | | | | | | |
| Вируст хепатит | тоо | 23 | 10 | 18 | 8 | 80.0 |
| | 10000 хүнд | 1.0 | 0.4 | 0.7 | 0.3 | |
| Цусан суулга | тоо | 209 | 248 | 137 | -111 | -44.7 |
| | 10000 хүнд | 9.3 | 10.0 | 5.2 | -4.8 | |
| Улаан эсэргэнэ | тоо | 117 | 64 | 70 | 6 | 9.4 |
| | 10000 хүнд | 5.2 | 2.6 | 2.6 | - | |
| Сальмонеллёз | тоо | 28 | 47 | 57 | 10 | 21.3 |
| | 10000 хүнд | 1.2 | 1.9 | 2.1 | 0.2 | |
| Салхин цэцэг | тоо | 852 | 660 | 594 | -66 | -10.0 |
| | 10000 хүнд | 38.0 | 26.6 | 22.3 | -4.3 | |
| Гахайн хавдар | тоо | 10 | 31 | 10 | -21 | -67.7 |
| | 10000 хүнд | 0.4 | 1.2 | 0.4 | -0.8 | |
| Ёлом | тоо | 6 | 18 | 12 | -6 | -33.3 |
| | 10000 хүнд | 0.3 | 0.7 | 0.5 | -0.2 | |
| Гар хөл, амны өвчин | тоо | 369 | 179 | 168 | -11 | -6.1 |
| | 10000 хүнд | 16.5 | 7.2 | 6.3 | -0.9 | |
| Тэмбүү | тоо | 112 | 102 | 83 | -19 | -18.6 |
| | 10000 хүнд | 5.0 | 4.1 | 3.1 | -1.0 | |
| Заг хүйтэн | тоо | 43 | 71 | 55 | -16 | -22.5 |
| | 10000 хүнд | 1.9 | 2.9 | 2.1 | -0.8 | |
| Трихомониаз | тоо | 14 | 16 | 9 | -7 | -43.7 |
| | 10000 хүнд | 0.6 | 0.6 | 0.3 | -0.3 | |
| Сүрьеэ | тоо | 151 | 157 | 123 | -34 | -21.6 |
| | 10000 хүнд | 6.7 | 6.3 | 4.6 | -1.7 | |
| Улаан бурхан | тоо | 0 | 0 | 2186 | 2186 | 100.0 |
| | 10000 хүнд | 0.0 | 0.0 | 82.2 | 82.2 | |
| Коронавирус – (Covid 19) | тоо | 0 | 1 | 1 | - | - |
| | 10000 хүнд | 0.0 | 0.0 | 0.0 | - | |
| Бусад | тоо | 25 | 107 | 793 | 686 | 7.4** |
| | 10000 хүнд | 1.1 | 4.3 | 29.9 | 25.6 | |

## ЗУРАГ 2. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД




**Ойлголт, тодорхойлолт:**

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт

болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

# НИЙГМИЙН ДААТГАЛ

## Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын орлого 601.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.2 хувиар буурсан байна.

2025 оны эхний 11 дүгээр сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 601.4 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 7.3 (1.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. 2025 оны эхний 11 дүгээр сард орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.9 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**ХҮСНЭГТ 5.** НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сан тус бүрээр, 2025 оны эхний XI сард

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | | Гүйцэтгэл | | Биелэлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2024 I-XI | 2025 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI | Хувь | |
| **Нийт дүн** | **577 163.2** | **608 787.1** | **299 540.4** | **601 445.2** | **-48.1** | **-1.2** |
| Тэтгэврийн даатгалын сангийн орлого | 487 314.6 | 514 902.4 | 257 585.7 | 496 379.4 | -47.1 | -3.6 |
| Тэтгэмжийн сангийн орлого | 43 661.1 | 46 267.3 | 21 865.0 | 52 834.3 | -49.9 | 14.2 |
| ҮОМШӨ-ний даатгалын орлого | 29 481.0 | 29 795.7 | 2 315.8 | 33 436.2 | -92.1 | 12.2 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого | 16 705.6 | 17 821.7 | 17 773.0 | 18 795.3 | 6.4 | 5.5 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого | 0.9 | - | 0.9 | - | 0 | 0 |

Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.5 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.8 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 5.6 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 3.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 3.** НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ДААТГАЛЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



**ЗУРАГ 4.** НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 23527 хүнд 261.7 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3438 хүнд 25.2 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 1156 хүнд 8.5 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1651 хүнд 28.7 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 10634 хүнд 5.5 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 3833 хүнд 18.3 тэрбум төгрөгийг, 709 хүнд оршуулгын тэтгэмж 1.47 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 143 хүнд 1.76 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 244.3 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 280 хүнд 592.5 сая төгрөгийг, тус тус олгосон байна. ҮОМШӨ-ний бусад зардалд 87 хүнд 133.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Ажилгүйдлийн тэтгэмж авсан 4042 хүнд 19.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Мөн ажил олгогч даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээнд 6.9 сая төгрөг зарцуулсан байна.

**ЗУРАГ 5.** НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



## ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО




<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Нийгмийн даатгал</u> нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

<u>Нийгмийн даатгалын</u> сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

<u>Даатгуулагч</u> гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

<u>Тэтгэвэр</u> гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

<u>Тэтгэмж</u> нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

# Халамж

2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн зарлагын 110.5 (68.8%) тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгө буюу 105271 хүнд, алдарт эхийн одонгийн тусламж 3.3 (2.1%) тэрбум төгрөг, насны хишиг 2.2 (1.4%) тэрбум төгрөг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 6.38 (4.0%) тэрбум төгрөг, нийгмийн халамж 37.7 (23.5%) тэрбум төгрөг, хүнс, тэжээлийн дэмжлаг үзүүлэх үйлчилгээ 197.5 (0.1%) сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт 153.6 (0.1%) сая төгрөг тус тус зарцуулсан байна.

**ХҮСНЭГТ 6.** НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая төгрөг

| Үзүүлэлт | 2025 I-XI | |
|---|---|---|
| | Дүн | Хүний тоо |
| **Нийт зарлагын дүн** | **160 617.8** | **182 276** |
| Нийгмийн халамжийн сан | 37 715.9 | 27 985 |
| Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж | 6 380.5 | 17 586 |
| Алдарт эхийн одонгийн тусламж | 3 359.1 | 14 389 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | 153.6 | 496 |
| Хүүхдийн мөнгө | 110 539.5 | 105 271 |
| Насны хишиг | 2 257.3 | 14 885 |
| Онцгой тохиолдолд олгох тэтгэмж | 14.4 | 12 |
| Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ | 197.5 | 1 652 |

## Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн халамж гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа;

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.

# ГЭМТ ХЭРЭГ

2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт 5164 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 773(17.6%) хэргээр өссөн үзүүлэлттэй байна.

**ХҮСНЭГТ 7.** **БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**

| Төрөл | Гэмт хэргийн тоо | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI | Тоо | Хувь |
| Дүүргийн дүн | 3 667 | 4 391 | 5 164 | 773 | 17.6 |
| Хүний амь | 13 | 11 | 14 | 3 | 27.3 |
| Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 28 | 27 | 37 | 10 | 37.0 |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 555 | 527 | 685 | 158 | 30.0 |
| Хүчин | 34 | 37 | 55 | 18 | 48.6 |
| Хулгай | 422 | 873 | 1 013 | 140 | 16.0 |
| Малын хулгай | 9 | 2 | 5 | 3 | 2.5** |
| Дээрэм | 11 | 39 | 53 | 14 | 35.9 |
| Залилан | 1 961 | 2 062 | 2 095 | 33 | 1.6 |
| Олон нийтийн амгалан тайван байдал | 1 | - | 1 | - | - |
| Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих | 102 | 177 | 276 | 99 | 55.9 |
| Бусад | 531 | 636 | 930 | 294 | 46.2 |

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 40.6 хувийг залилан, 13.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19.6 хувийг хулгай, 5.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих, 1.1 хувийг хүчин, 1.0 хувийг дээрэм, 0.7 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 0.3 хувийг хүний амь, 0.1 хувийг малын хулгай, 18.0 хувийг бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 7.** **БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар**



## ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ

| Хэлтэс | Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг | | | Өөрчлөлт 2025/2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI | Тоо | Хувь |
| **Нийслэлийн дүн** | **23 405** | **28 067** | **30 967** | **2 900** | **10.3** |
| Хан-Уул дүүргийн дүн<br>Үүнээс: Цагдаагийн хэлтсээр | 3 667 | 4 391 | 5 164 | 773 | 17.6 |
| I хэлтэс | 2 368 | 2 866 | 2 979 | 113 | 3.9 |
| II хэлтэс | 1 299 | 1 525 | 2 185 | 660 | 43.3 |
| Нийслэлийн дунд эзлэх хувь | 15.7 | 15.6 | 16.7 | 26.6 | 1.1 |

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дунд эзлэх хувь 16.7 байгаа нь өмнөх оны мөн үетэй 1.1 нэгж хувиар өссөн байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 57.7 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

## ХҮСНЭГТ 9. ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, хэлтсээр

| Хэлтэс | Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг | | Эмэгтэй хүн оролцсон | | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2024 I-XI | 2025 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI | 2024 I-XI | 2025 I-XI |
| **Дүүргийн дүн** | **301** | **319** | **426** | **688** | **99** | **108** |
| I хэлтэс | 161 | 157 | 293 | 498 | 57 | 51 |
| II хэлтэс | 140 | 162 | 133 | 190 | 42 | 57 |

Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт 2025 оны эхний 11 дүгээр сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас 108 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 9(9.1%) хэргээр өссөн байна. Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн улмаас хохирсон 4917 иргэн хохирсоны 2308(46.9%) нь эмэгтэйчүүд байсан бол 15 (0.3%) нь 7 хүртэлх насны хүүхэд, 95(1.9%) нь 8-13 насны хүүхэд, 171 (3.4%) нь 14-17 насны хүүхдүүд хохирсон байна.

Гэмт хэргийн улмаас 807 хүн гэмтэж осолдон, 69 хүн нас барж, төр, ард иргэдэд 165252.0 сая төгрөгийн хохирол учруулсны 72334.0 (43.8%) сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2025 оны эхний 11 дүгээр сард тус дүүргийн 15 дугаар хороонд 599 гэмт хэрэг гарч хамгийн өндөр, 7-р хорооны нутаг дэвсгэрт хамгийн бага буюу 42 гэмт хэрэг гарсан байна.

## ХҮСНЭГТ 10. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, төрлөөр

| Хороо | Нийт дүн | Хүнийг алах | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Хүчин | Хулгай | Үүнээс | | | Дээрэм | Залилан | Малын хулгай | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ИӨХ | Авто тээврийн хэрэгсэл хулгайлах | Халаасны хулгай | | | | | | |
| Нийт дүн | 5 164 | 14 | 37 | 685 | 55 | 1 013 | 800 | 29 | 54 | 53 | 2 095 | 5 | 276 | 1 | 930 |
| 1-р хороо | 148 | | 1 | 22 | 2 | 23 | 20 | | 1 | 2 | 65 | | 9 | | 24 |
| 2-р хороо | 195 | | 1 | 21 | | 49 | 40 | 2 | 2 | | 84 | | 10 | | 30 |
| 3-р хороо | 356 | | 2 | 46 | 5 | 52 | 45 | 1 | 1 | 5 | 155 | | 42 | | 49 |
| 4-р хороо | 277 | 1 | | 14 | 2 | 32 | 23 | 1 | 4 | | 183 | | 19 | | 26 |
| 5-р хороо | 83 | 1 | | 20 | | 12 | 8 | 2 | | | 21 | | 8 | | 21 |
| 6-р хороо | 90 | | | 12 | 2 | 9 | 5 | | 2 | | 38 | | 11 | | 18 |
| 7-р хороо | 42 | | | 11 | 1 | 6 | 5 | | | 1 | 10 | | 9 | | 4 |
| 8-р хороо | 161 | 1 | 3 | 30 | 7 | 25 | 11 | 1 | 1 | 1 | 38 | 1 | 20 | | 35 |
| 9-р хороо | 73 | | 1 | 12 | 1 | 18 | 10 | 1 | | 3 | 18 | | 5 | | 15 |
| 10-р хороо | 115 | | 1 | 22 | 4 | 27 | 19 | 1 | | | 37 | | 11 | | 13 |
| 11-р хороо | 377 | 2 | 4 | 75 | 2 | 80 | 71 | | 3 | 2 | 133 | | 9 | | 70 |
| 12-р хороо | 76 | 1 | 2 | 19 | 2 | 19 | 16 | | | 2 | 11 | | 8 | | 12 |
| 13-р хороо | 39 | 1 | 1 | 10 | | 7 | 5 | 1 | | 1 | 10 | 1 | 4 | | 4 |
| 14-р хороо | 116 | 1 | 1 | 28 | 4 | 39 | 25 | 1 | | 0 | 20 | 3 | 6 | | 14 |
| 15-р хороо | 599 | | 1 | 93 | 3 | 151 | 121 | 1 | 24 | 8 | 214 | | 22 | | 107 |
| 16-р хороо | 86 | | 2 | 17 | 1 | 22 | 14 | 2 | | | 20 | | 11 | | 13 |
| 17-р хороо | 283 | | 1 | 22 | 4 | 94 | 86 | 1 | | 5 | 94 | | 8 | 1 | 54 |
| 18-р хороо | 270 | | | 20 | | 63 | 60 | | | 6 | 114 | | 7 | | 60 |
| 19-р хороо | 226 | 1 | 3 | 25 | 1 | 37 | 33 | | 1 | 4 | 105 | | 8 | | 42 |
| 20-р хороо | 454 | | 3 | 25 | 2 | 43 | 41 | | 1 | | 296 | | 7 | | 78 |
| 21-р хороо | 307 | 1 | 4 | 40 | 3 | 62 | 42 | 5 | 3 | 7 | 114 | | 8 | | 68 |
| 22-р хороо | 71 | | | 11 | 2 | 15 | 13 | | | 1 | 23 | | 5 | | 14 |
| 23-р хороо | 281 | | 2 | 36 | 2 | 49 | 32 | 3 | 3 | | 122 | | 8 | | 62 |
| 24-р хороо | 288 | 3 | 3 | 41 | 5 | 51 | 37 | 1 | 6 | 3 | 105 | | 13 | | 64 |
| 25-р хороо | 151 | 1 | 1 | 13 | | 28 | 18 | 5 | 2 | 2 | 65 | | 8 | | 33 |

# ДҮҮРГИЙН ТӨСӨВ

## Дүүргийн төсвийн нийт орлого 463.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 76.7 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2025 оны эхний 11 дүгээр сарын байдлаар 463.4 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 76.7 (14.2%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2024 оноос 15.5 хувиар өссөн байна. Төсвийн нийт орлогын 97.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 2.4 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого, улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг) эзэлж байна.

**ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг**




Татварын орлогын хэмжээ 452.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 80.6(15.1%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн бол татварын бус орлого 10.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 3.9(55.4%) тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн байна.

**ХҮСНЭГТ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 11 сарын байдлаар**

| | Төсвийн орлого | | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Татварын орлого | | | Татварын бус орлого | | |
| | Бүгд | ТБ % | Зөрүү | Бүгд | ТБ % | Зөрүү | Бүгд | ТБ % | Зөрүү |
| | сая төгрөг | | | | | | | | |
| Дүн | 463 406.8 | -14.2 | -76 752.8 | 452 500.8 | -15.1 | -80 639.9 | 10 906.0 | 55.4 | 3 887.1 |

Орлогын албан татвар төлөвлөснөөс 76.7 тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 5.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн бол хөрөнгийн албан татвар 1.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

## ХҮСНЭГТ 12. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 11 сард

| Үзүүлэлт | Төлөвлөсөн | Гүйцэтгэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | сая төгрөг | | Хувь | Дүн |
| **Орон нутгийн орлого** | **540 159.6** | **463 406.8** | **-14.2** | **-76 752.8** |
| 1.Татварын орлогын дүн | 533 140.7 | 452 500.8 | -15.1 | -80 639.9 |
| 1.1 Орлогын албан татвар | 458 314.7 | 381 578.6 | -16.7 | -76 736.2 |
| Хувь хүний орлогын албан татвар | 458 314.7 | 381 578.6 | -16.7 | -76 736.2 |
| 1.2 Хөрөнгийн албан татвар | 22 310.7 | 23 645.8 | 6.0 | 1 335.1 |
| 1.3 Бусад татвар,төлбөр, хураамж | 52 515.3 | 47 276.4 | -10.0 | -5 238.9 |
| 1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 18 576.3 | 16 039.9 | -13.7 | -2 536.3 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 13 750.0 | 12 196.3 | -11.3 | -1 553.7 |
| Ашигт малтмал ашигласны төлбөр | 242.9 | 144.5 | -40.5 | -98.5 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 4 583.4 | 3 699.1 | -19.3 | -884.2 |
| 1.3.2 Газрын төлбөр | 33 893.2 | 31232.3 | -7.9 | -2 661.0 |
| 1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 45.8 | 4.2 | -90.7 | -41.6 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 45.8 | 4.2 | -90.7 | -41.6 |
| 2.Татварын бус орлогын дүн | 7 018.9 | 10 906.0 | 55.4 | 3 887.1 |
| 2.1 Нийтлэг татварын бус орлого | 4 441.6 | 8 900.2 | 1.0** | 4 458.7 |
| Торгуулийн орлого | 3 666.7 | 8 096.5 | 1.2** | 4 429.9 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого* | 737.1 | 750.0 | 1.7 | 12.8 |
| Бусад орлого | 37.8 | 53.7 | 42.1 | 15.9 |
| 2.2 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 2 577.3 | 2 005.8 | -22.2 | -571.5 |

## ЗУРАГ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



## ХҮСНЭГТ 13. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний 11 сард, сая төгрөг

| Үзүүлэлт | Зарлага | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Дүн |
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **444 729.2** | **402 780.4** | **-9.4** | **-41 948.8** |
| 1.Урсгал зарлага | 408 802.5 | 372 339.9 | -8.9 | -36 462.4 |
| 1.1 Бараа, үйлчилгээний зардал | 101 890.7 | 95 924.0 | -5.9 | -5 966.7 |
| Цалин хөлс | 17 208.1 | 13 197.7 | -23.3 | -4 010.4 |
| Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж | 2 150.2 | 1 495.3 | -30.5 | -654.9 |
| Бараа, үйлчилгээний бусад зардал | 82 532.4 | 81 231.0 | -2.6 | -1 301.4 |
| 1.2 Татаас ба урсгал шилжүүлэг | 306 911.8 | 276 415.9 | -9.9 | -30 495.9 |
| Татаас | - | - | - | - |
| Урсгал шилжүүлэг | 306 911.8 | 276 415.9 | -9.9 | -30 495.9 |
| 2. Хөрөнгийн зардал | 35 926.7 | 30 440.5 | -15.3 | -5 486.2 |
| Барилга байгууламж | 14 285.2 | 12 559.7 | -12.1 | -1 725.5 |
| Тоног төхөөрөмж | 984.7 | 984.7 | 0.0 | 0.0 |
| Бусад хөрөнгө | 20 656.8 | 16 896.0 | -18.2 | -3 760.8 |

Эх үүсвэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд үлдэгдэлгүй байсан бол шинээр өглөг үүсээгүй байна.

## ХҮСНЭГТ 14. ӨГЛӨГ, 2025 оны эхний XI сард, сая төгрөг

| | 11-р сарын эхний үлдэгдэл | Шинээр үүссэн өглөг | Тухайн сард төлөгдсөн | 11-р сарын эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| Нийт дүн | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

## Ойлголт, тодорхойлолт:

**Татварын орлого:** Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

**Татварын бус орлого:** Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

**Төсвийн орлого:** Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

## Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх сараас 9.9 хувиар өссөн байна.

Нийслэлийн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс 2025 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.7 хувь, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

**ЗУРАГ 10.** **ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС**




Хэрэглээний үнийн индекс 2025 оны 11 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 7.3 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 10.2 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис бүлгийн үнэ 6.7 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 6.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 5.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 8.2 хувь, тээвэр бүлгийн үнэ 2.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.2 хувь, боловсролын үйлчилгээний үнэ 13.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 7.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 9.1 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 11.1 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 15.** **ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр**

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2024-XI / 2023-XI | 2025-XI / 2024-XI | 2025-XI / 2024-XII | 2025-XI / 2025-X |
|---|---|---|---|---|
| Ерөнхий индекс | 7.9 | 8.7 | 7.3 | 0.4 |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 6.7 | 12.5 | 10.2 | 0.1 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 3.5 | 7.1 | 6.7 | 0.5 |
| Хувцас, бөс бараа, гутал | 8.7 | 7.8 | 6.4 | 1.9 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 23.3 | 7.8 | 5.7 | -0.7 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 8.2 | 8.8 | 8.2 | 0.4 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 5.1 | 6.3 | 6.2 | 0.1 |
| Тээвэр | 0.6 | 4.2 | 2.2 | 0.4 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 2.2 | 2.4 | 2.4 | 0.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 5.5 | 7.6 | 7.6 | 2.5 |
| Боловсролын үйлчилгээ | 19.7 | 13.6 | 13.6 | 0.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 7.8 | 9.6 | 9.1 | 0.2 |
| Даатгал, санхүүгийн үйлчилгээ | 2.3 | 6.1 | 6.1 | 0.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 9.1 | 11.2 | 11.1 | 2.2 |

2025 оны 11 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 418 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 144 (36.4%) бараа үйлчилгээний үнэ өсөж, 70 (16.7%) бараа үйлчилгээний үнэ буурч, 196 (46.9%) бараа үйлчилгээний үнэ тогтвортой байв.

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний сонгогдсон 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад элсэн чихэр 4800 төгрөг, “Үхрийн мах”, ястай мах 500 төгрөг, польш алим 3500 төгрөг, “Хонины мах”, ястай 3300 төгрөг, төмс 2200 төгрөг, сонгино тус бүр 1500 төгрөг, тараг, цөцгийтэй, “Сүү” ХК-ийн 610 төгрөг, дээд зэргийн гурил 450 төгрөг, Талх чихэр” ХК-ны “Атар” талх 350 төгрөг, байцаа болон цагаан будаа тус тус 300 төгрөг, 2-р зэргийн гурил 110 төгрөгөөр тус тус өссөн бол, манжин 1000 төгрөг, лууван 500 төгрөг, задгай сүү 100 төгрөгөөр буурсан байна. Харин 1-р зэргийн гурилын үнэ тогтвортой байна.

**ХҮСНЭГТ 16. БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 11 дүгээр сард**

| Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | 2024 XI | 2025 XI | Хувь |
|---|---|---|---|---|
| Талх “Атар”, “Талх чихэр” ХК | ширхэг | 2 400 | 2 750 | 14.6 |
| Хонины мах, ястай | кг | 11 500 | 14 800 | 28.7 |
| Үхрийн мах, ястай | кг | 19 000 | 19 500 | 2.6 |
| Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК, савласан | кг | 3 050 | 3 500 | 14.8 |
| Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай | кг | 2 660 | 2 660 | 0.0 |
| Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК, савласан | кг | 1 830 | 1 940 | 6.0 |
| Элсэн чихэр | кг | 4 500 | 9 300 | 2.1** |
| Төмс, монгол | кг | 1 100 | 3 300 | 3.0** |
| Байцай, монгол | кг | 2 500 | 2 800 | 12.0 |
| Лууван, монгол | кг | 3 500 | 3 000 | -14.3 |
| Манжин, монгол | кг | 4 500 | 3 500 | -22.2 |
| Сонгино, хятад | кг | 3 500 | 5 000 | 42.9 |
| Цагаан будаа | кг | 6 100 | 6 400 | 4.9 |
| Алим, Польш | кг | 8 000 | 11500 | 43.8 |
| Сүү, задгай | литр | 4100 | 4000 | -2.4 |
| Тараг, цөцгийтэй, “Сүү ” ХК | литр | 4 140 | 4 750 | 14.7 |

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсуврага” төв

**ЗУРАГ 11. НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XI сард, төгрөг**



## ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XI сард, төгрөг




## ЗУРАГ 13. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн XI сард, төгрөг



## ХҮСНЭГТ 17 . НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

| ШТС | 2024.XI.19 | | | | | 2025.XI.20 | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Аи 95 | Аи 80 | Аи 92 | Дизель түлш | Газ | Аи 95 | Аи 80 | Аи 92 | Дизель түлш | Газ |
| **Дундаж үнэ** | **3 910** | **-** | **2 390** | **3 140** | **1 790** | **3 707** | **-** | **2 590** | **3 006** | **1 950** |
| Петровис | 3 910 | - | 2 390 | 3 140 | - | 3 610 | - | 2 590 | 3 140 | - |
| Магнай трейд | 3 910 | - | 2 390 | 3 140 | - | 3 910 | - | 2 590 | 2 940 | - |
| Шунхлай | 3 910 | - | 2 390 | 3 140 | - | 3 610 | - | 2 590 | 2 940 | - |
| Юнигаз | - | - | - | - | 1 790 | - | - | - | - | 1 950 |

Эх үүсвэр: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 11 дүгээр сарын мэдээ

**Ойлголт, тодорхойлолт:**

**Хэрэглээний сагс:** Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

**Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:** Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

**Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):** Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

**Тооцох аргачлал:**

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$I_{ct}^{L}$ – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
$P_t^i$ – i барааны тайлант үеийн үнэ
$P_0^i$ – i барааны тайлант үеийн үнэ
$q_0^i$ – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.

# ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

## Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 11 дүгээр сард -8.8 $^0$C байв.

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 11 дүгээр сард -8.8 $^0$C байгаа нь өмнөх оны мөн үеийн дундажтай харьцуулбал 1.6$^0$C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 10.0$^0$C, хамгийн хүйтэн хэм -30.0$^0$C, хур тунадасны нийлбэр 11.1 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 20 метр секунд хүрсэн байна.

**ХҮСНЭГТ 18. АГААРЫН БОХИРДОЛТ, XI сард**

| Бодисын нэр | | Стандарт хэмжээ | Хэмжилтийн тоо | Хамгийн их хэмжээ | Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо | Агаарт байсан дундаж хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|
| Хүхэрлэг хий, мг/м$^3$ | $SO_2$ | 0.050 | 389 | 0.211 | 85 | 0.035 |
| Азотын давхар исэл, мг/м$^3$ | $NO_2$ | 0.050 | 405 | 0.162 | 183 | 0.050 |
| Тоосжилт, мг/м$^3$ | $PM_{10}$ | 0.100 | 463 | 1 284 | 194 | 0.104 |
| | $PM_{2.5}$ | 0.050 | 465 | 0.258 | 257 | 0.049 |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м$^3$ | CO | 10.000 | 338 | 46 721 | 22 | 1.818 |
| Озон, мг/м$^3$ | $O_3$ | 0.100 | 596 | 0.093 | - | 0.020 |

2025 оны 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад азотын давхар исэл 0.009 мг/м$^3$ -ээр, PM 10 тоосонцор 0.002 мг/м$^3$-ээр, PM 2.5 тоосонцор 0.004 мг/м$^3$ -ээр, их, нүүрс төрөгчийн дутуу исэл 0.303 мг/м$^3$ -ээр, озон 0.002 мг/м$^3$-ээр тус тус их, хүхэрлэг хий 0.019 мг/м$^3$-ээр бага байна.

## ХҮСНЭГТ 19. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м3, XI сард

| Агаарын бохирдлын үзүүлэлт | | Мишээл Экспо төв | | | Богд хааны ордон музей | | Нисэх | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2023 | 2024 | 2025 |
| Хүхэрлэг хий $SO_2$ | Дундаж | 0.026 | 0.025 | 0.024 | 0.015 | 0.037 | - | - | 0 |
| | Хамгийн их | 0.061 | 0.062 | 0.046 | 0.04 | 0.077 | - | - | 0 |
| | ХХХ*-с давсан % | 7 | 3 | | - | 27 | - | - | 0 |
| | Хэмжилтийн тоо | 30 | 30 | 30 | 30 | 30 | - | - | 0 |
| Азотын давхар исэл $NO_2$ | Дундаж | 0.025 | 0.028 | 0.035 | 0.035 | 0.044 | 0.052 | 0.043 | 0 |
| | Хамгийн их | 0.079 | 0.106 | 0.131 | 0.054 | 0.062 | 0.091 | 0.076 | 0.000 |
| | ХХХ*-с давсан % | 7 | 10 | 24 | 10 | 37 | 56 | 39 | 0 |
| | Хэмжилтийн тоо | 14 | 30 | 29 | 30 | 30 | 16 | 28 | 0 |
| Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO** | Дундаж | 0.985 | 0.08 | 1.212 | 0.433 | 0.8 | 1.707 | 1.27 | 1.218 |
| | Хамгийн их | 4209 | 3048 | 5.334 | 1.418 | 2.145 | 10.823 | 5.293 | 2.4 |
| | ХХХ*-с давсан % | - | - | 3 | - | 0 | 1 | - | 0 |
| | Хэмжилтийн тоо | 82 | 90 | 27 | 90 | 30 | 87 | 90 | 27 |
| Тоос $PM_{10}$ | Дундаж | 0.050 | 0.080 | 0.068 | 0.069 | 0.048 | 0.044 | 0.075 | 0.050 |
| | Хамгийн их | 0.099 | 0.177 | 0.141 | 0.138 | 0.121 | 0.098 | 0.129 | 0.119 |
| | ХХХ*-с давсан % | - | 20 | 17 | 17 | 7 | - | 23 | 7 |
| | Хэмжилтийн тоо | 30 | 30 | 30 | 30 | 30 | 25 | 30 | 30 |
| Тоос $PM_{2.5}$ | Дундаж | - | 0.025 | 0.019 | 0.013 | 0.02 | 0.036 | 0.034 | 0.03 |
| | Хамгийн их | - | 0.078 | 0.041 | 0.038 | 0.06 | 0.085 | 0.066 | 0.057 |
| | ХХХ*-с давсан % | - | 3 | 4 | - | 14 | 32 | 10 | 27 |
| | Хэмжилтийн тоо | - | 30 | 28 | 30 | 29 | 25 | 30 | 30 |
| Озон О3** | Дундаж | 0.021 | 0.027 | 0.023 | - | | 0.033 | 0.030 | 0.027 |
| | Хамгийн их | 0.075 | 0.064 | 0.061 | - | | 0.078 | 0.082 | 0.065 |
| | ХХХ*-с давсан % | - | 0 | 0 | - | | - | - | 0 |
| | Хэмжилтийн тоо | 90 | 90 | 90 | - | 0.037 | 86 | 90 | 90 |

**Ойлголт, тодорхойлолт**

**Агаарын бохирдол**: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

**Аюулт үзэгдэл:** Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

**Гамшиг:** Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

**Зөвшөөрөгдөх түвшин**: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

**Хүлцэх агууламж:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

# ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2025 оны эхний 11 дүгээр сад Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 4620 өргөдөл, гомдол ирүүлснээс 4446 (96.2%)-ийг шийдвэрлэн хуулийн дагуу хугацаанд хариу өгч, шийдвэрлэх хугацаа болоогүй 73 (3.7%), хугацаа хэтэрсэн 1 (0.1%) өргөдөл гомдол байна.

**ХҮСНЭГТ 20. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ-ын шийдвэрлэлтийн мэдээ**

| Өргөдөл, гомдлын агуулга | Өргөдөл гомдлын тоо | АГУУЛГА | | | | | Хуулийн хугацаанд хариу өгсөн | Хугацаа болоогүй | Хугацаа хэтэрсэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүсэлт | Гомдол | Талархал | Санал | Мэдэгдэл | | | |
| НИЙТ ДҮН | 4 620 | 2 810 | 1 457 | 301 | 48 | 4 | 4 446 | 73 | 1 |
| Төрийн захиргааны удирдлагын хэлтэс | 151 | 92 | 41 | 16 | 2 | | 151 | | |
| Санхүү төрийн сангийн хэлтэс | 7 | 5 | 2 | | | | 7 | | |
| Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс | 60 | 35 | 20 | | 5 | | 59 | 1 | |
| Нийгмийн хөгжлийн хэлтэс | 15 | 8 | 7 | | | | 15 | | |
| Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс | 339 | 141 | 187 | | 11 | | 330 | 9 | |
| Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс | 248 | 129 | 118 | | 1 | | 243 | 5 | |
| Хууль, эрх зүйн хэлтэс | 32 | 15 | 13 | | | 4 | 31 | 1 | |
| Архивын хэлтэс | 21 | 21 | | | | | 21 | | |
| Цэргийн штаб | 123 | 123 | | | | | 123 | | |
| ЗДТГ-ын дүн | 996 | 569 | 388 | 16 | 19 | 4 | 980 | 16 | 0 |
| Насан туршийн суралцахуйн төв | 31 | 31 | | | | | 31 | | |
| Боловсролын хэлтэс | 493 | 69 | 373 | 38 | 13 | | 489 | 4 | |
| Газар зохион байгуулалтын алба | 1475 | 1176 | 282 | 3 | 14 | | 1449 | 25 | 1 |
| Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс | 124 | 115 | 9 | | | | 122 | 2 | |
| Нийгмийн даатгалын газар | 93 | 42 | 50 | 1 | | | 92 | 1 | |
| Татварын хэлтэс | 636 | 610 | 25 | 1 | | | 92 | 1 | |
| Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс | 231 | 166 | 59 | 6 | | | 228 | 3 | |
| Улсын бүртгэлийн хэлтэс | | | | | | | | | |
| Цагдаагийн 1-р хэлтэс | 363 | 18 | 149 | 195 | 1 | | 354 | 9 | |
| Цагдаагийн 2-р хэлтэс | 178 | 14 | 122 | 41 | 1 | | 176 | 2 | |
| **Дэргэдэх хэлтэс, албадын дүн** | 3624 | 2241 | 1069 | 285 | 29 | 0 | **3566** | 57 | 1 |

# БҮЛЭГ

## ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН

| | | |
|---|---|---|
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он | |
| | Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр | |
| I | Эрүүл мэнд | Ц.Энх-Оюун |
| II | Нийгмийн даатгал | Т.Баттулга |
| III | Нийгмийн халамж | Т.Баттулга |
| IV | Гэмт хэрэг | Б.Тодмаа |
| V | Төсөв | Ж.Энх-Амгалан |
| VI | Хэрэглээний үнэ | Ж.Энх-Амгалан |
| VII | Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол | Т.Баттулга |
| VIII | Захиргааны мэдээ | Т.Баттулга |